



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 1/07

Пионер толгой


Иргэний танхимын тохижилтын
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны төсөв батлах тухай 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 10/02 тоот тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсөвт тусгагдсан Иргэний танхимын ажлыг “Санаа мед трейд” ХХК -тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Дээрх ажилд шаардагдах 35.000.000 (Гучин таван сая) төгрөгийг “Санаа мед трейд” ХХК-ний холбогдох баримтыг үндэслэн олгохыг сан хариуцсан нягтлан бодогч (Б.Няммэший)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

642201167

/2022/Засаг дарга/Захирамж-2022



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар A/08

Пионер толгой

Г Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.1, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 20 дугаар зүйлийн 20.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.3, 18 дугаар зүйлийн 18.1, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн A/122 тоот тушаалаар“ Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” –ын 2.1, 14.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт 11 сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд хурдан морины уралдаан, бооцоот уралдаан, мялаалга найрын уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаа зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

2. Өвөл, хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдааны үед үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаварыг олон нийт, уяачид, эцэг эхчүүдэд цаг алдалгүй сурталчилж, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг багийн Засаг дарга нар, “Аравгар хээр” морин спорт уяачдын холбооны тэргүүн (Г.Ууганбаяр), тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сар бүрийн 25-ны дотор Засаг даргын зөвлөлд тайлagnаж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Мөнхдалай) нарт даалгасугай.

ДАРГА

Б.ГАНТУЛГА

642201175